



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/32/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхцэцэг Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn Аудитор: Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.08.24 № 1-6/119

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД
СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА У.ЭНХМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	390.3	1,773.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,969.6	11,150.4
	Нийт хөрөнгийн дүн	2,359.9	12,923.9
	Нийт өр төлбөрийн дүн	113.7	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,246.2	12,923.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,359.9	12,923.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,177.7	16,876.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,647.2	6,185.4
	Үйл ажиллагааны үр дүн	530.5	10,691.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	(3.7)	(13.4)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	526.8	10,677.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,246.2	2,246.2
	Тайлант оны үр дүн		10,677.7
	Эцсийн үлдэгдэл	2,246.2	12,923.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,356.7	4,833.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,279.9	4,765.0
	Үйл ажиллагааны ЦМГ	76.9	68.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-71.9	-67.9
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	5.0	0.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		3,922.3
	Урсгал зардал		3,922.3
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		3,667.9
	Улсын төсвөөс санхүүжих		3,311.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		131.3

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэвтэн эмчлүүлэх, амбулаторийн үзлэг ,оношилгоо шинжилгээ түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлдэг.

Эрхэм зорилго: Мэргэжилтнээ дэмжиж үйлчлүүлэгчээ хүндэлсэн орчин үеийн нотолгоонд тулгуурласан чадварлаг баг эмнэлгийн тусламж үйлчилгээг хариуцлагатай ээлтэй тэгш хүртээмж үзүүлэхэд оршино.

Алсын хараа: Ес зүйг эрхэмлэсэн стандартад нийцсэн чанартай цогц үйлчилгээг үзүүлэгч хоёрдогч шатлалын эмнэлэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

ГУРАВ. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ЭМЯ-ны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 4/422 тоот албан бичгийн дагуу эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь 2021 оноос эхлэн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг авч эхэлсэн байна. Мөн тайлант онд тус байгууллагын харилцах дансны 0.8 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 142 мэдээллийг хугацаандаа оруулсан, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 4,710.4 сая төгрөгийн 51 гүйлгээнээс 2,777.1 сая төгрөгийн 36 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын нийт 1,158.9 сая төгрөгийн 84 ажил гүйлгээнээс 77.1 сая төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна. Хөрөнгө зарцуулах 823.8 сая төгрөгийн 19 тушаал, шийдвэр гарсан ба системд 70.2 сая төгрөгийн 3 тушаал, шийдвэрийг байршуулаагүй байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 120.8 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 120.8 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

Залруулсан алдаа:

1. 2021 онд шинээр ашиглалтад орсон болон 2020 онд ашиглалтад орсон нийт 8 нэр төрлийн 185.1 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах жил оруулаагүйгээс шалтгаалан 3.9 сая төгрөгийн элэгдэл тооцоогүй байсныг залруулав.

2. 210401-бичиг хэргийн 0.6 сая төгрөгийн зардлыг 210809- улсын мэдээллийн маягт хэвлэх зардалд, 210406-БҮТЭЗ-ийн 30.1 сая төгрөгийн зардлыг 210405- хог хаягдлын зардалд, 210403-шуудан холбооны 3.2 сая төгрөгийн зардлыг 210806-мэдээллийн технологийн үйлчилгээ зардалд, 210401-бичиг хэргийн 0.1 сая төгрөгийн зардлыг 210809-улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардалд тус тус хаасан ба нийт 34.0 сая төгрөгийн зардлыг залруулав.

3. Эрүүл мэндийн газраас ирүүлсэн үнэ төлбөргүй хуваарилсан бараа материалыг тулгахад зөрүү үүсээгүй байна. Харин ХӨСҮТ-өөс хуваарилсан 56.2 сая төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй байсныг залруулав.

4. Тохируулах бичилтийг буруу хийснээс үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 26.6 сая төгрөгөөр нэмэгдсэнийг залруулав.

Албан шаардлага:

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 4,710.4 сая төгрөгийн 51 гүйлгээнээс 2,777.1 сая төгрөгийн 36 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын нийт 1,158.9 сая төгрөгийн 84 ажил гүйлгээнээс 77.1 сая төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна. Хөрөнгө зарцуулах 823.8 сая төгрөгийн 19 тушаал, шийдвэр гарсан ба системд 70.2 сая төгрөгийн 3 тушаал, шийдвэрийг байршуулаагүй байна.

Мэдээллийг нөхөн байршуулах, хугацаандаа байршуулах, цаашид хугацаа хоцроох, мэдээллийг байршуулахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 419.5 сая төгрөгийн 125 нэр төрлийн 180 хөрөнгө байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, баталж мөрдөөгүй байна.

Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар цалингийн өглөг үүсгээгүй, ХХОАТ, НДШ-ийн өглөгийг цалингийн зардалтай шууд харьцуулж бүртгэсэн, урьд оны ХХОАТ-ын авлагыг шууд зардалд хаасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, эсхүл дахин шинээр үнэлгээ тогтоон цаашид ашиглах асуудлыг шийдвэрлэх.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, баталж, дагаж мөрдөх

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ									

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг	8	120.8	4	120.8	-	-	1	-	3	-
НИЙТ		8	120.8	4	120.8	-	-	1	-	3	-